

АНГЛИ ХЭЛЭНД ОРСОН ГАДААД ҮГС

(Орчуулга-Сурталчилгаа-Судалгааны өгүүлэл)

Nowadays, some essential needs becoming more imminently that studying English among Mongolian youths and professional people. Therefore, several social and economic important steps have been made in this field. Learning English becomes foremost goal as a foreign language in many schools and universities also its' program time has increased. Many teaching staffs had been trained. English dictionaries, phrase and text books, CD and TV lessons and English courses are counted as a hundreds. As a result of this, most Mongolian intellectuals can speak, write and understand English.

Next step of English language acquisition requires us to transit and deepen into relatively higher level. Clarifying, researches must explore English while studying. In this development stage, we expect that many activities were put into practice which are Mongolian-English comparative and contrastive analysis, grammar and composition features study, various fields' professional translators and interpreters such as science, politics, economics, literature, religion ... etc training and term-terminology processing. We still need to put an attention into historical development of English, its' grammatical features and vocabulary evolution. Therefore, I have chosen and translated some researchers' masterpieces into Mongolian whose are Henry Bradley, J.A. Sheard and Otto Jespersen (His work "Growth and structure of the english language" awarded the French Institute). Although these sources were published in 1960, but still have not lost their significance today. Also, we have used up to dated materials from professional sites in internet. We hope these translating-advertising work will contribute to the dual language study.

Түлхүүр үг: гадаад үгс, нэр томъёо, үгсийн сан

Цаг хугацаа өнгөрөх бүр хүний орчин ахуй, амьдрах хэв маяг, нийгмийн сэтгэл зүй өөрчлөгдөж байдаг. Хэл ч мөн ялгаагүй. Аливаа нээлт, өөрчлөлт шинэчлэлт бүр шинэ шинэ ухагдахууныг бий болгож, эдгээрийг тэмдэглэх нэрлэлт үгс, нэр томъёо үүсч, улмаар тухайн хэлний үгийн сан баяжиж байдаг билээ. Шинэ ухагдахууныг тэмдэглэхдээ хэлний үгийн сангаас бэлэн нөөц үгийг ашиглах, үг бүтээх зүй тогтлын дагуу шинэ үг бүтээх, аль аль нь боломжгүй бол гадаад хэлээс үг зээлдэх арга байдаг. Энд гадаад үг гэж шууд ярихаас өмнө Британи арлуудын хамгийн анхны оршин суугчид, тэдний хэл ярианы талаар жаахан тодруулга хийх хэрэгтэй гэж үзлээ. Энэ арлын анхны эзэд бол эртний Баруун Европчууд буюу Кэлтчүүд (Celt) байсан.

Англи хэлэнд гадаад үгс нэлээд жин дардаг ба англичууд энэ аралд ирэхээс өмнө гадаад үгийг авч хэрэглэх явдал эхэлсэн байдаг. Англи хэлэнд гадаад хэлний үг хоёр замаар нөлөөлж, орж ирдэг бөгөөд үүнд хоёр хүний хувийн харилцаа буюу ярианы хэлээр, нөгөө нь шууд бус харилцаагаар буюу утга зохиолоор дамжин бичгийн хэлээр орж ирдэг (Sheard, 1962, х.27). Манай эриний V зуунд Англи, Саксон, Жүүтээс бүрдсэн Герман овог аймгууд Британид ирснээр англи хэл анхлан бий болж хөгжсөн түүхтэй. Өөрөөр хэлбэл, англи хэл эртний герман хэлд суурилж хөгжсөн юм.

Британийн арлуудад анх ирж суурьшсан эдгээр хүмүүс Англи оронд "the land of the Angles" гэдэг нэрийг өгч, олон энгийн суурь нэр томъёо бүхий хэлээр хангажээ. Заримыг дурдвал: *man, woman, breed, work, eat, house, shire*. Тусдаа амьдарч байсан англо, саксончууд буюу германууд энд ирэхээс өмнө Ромын соёл иргэншилтэй харилцаатай байж, үүнд хамаарах объектууд, харийн чамин тансаг зүйлсийг илтгэх латин хэлний хэд хэдэн үг Германы олон үндэстэн, бараг бүх үндэстний хэлэнд орсон байна. Латин хэлний чулуун гудамж хэмээх утгатай *strata* үг нь англи хэлэнд *street*, герман хэлэнд *strasse*-р үлдсэн байна. Эх газрын оршин суугч-одоогийн англичуудын өвөг дээдсийн хэрэглэж байсан латин хэлээс гаралтай бусад үг хэллэг ч орчин цагийн англи хэлэнд уламжлагдан ирсэн бөгөөд тэдгээрээс заримыг дурдвал: *wine, butter, pepper, cheese, silk, copper, pound, inch, mile, mint* (латин хэлний *moneta-money-мөнгө*) байна.

Англичууд Британид ирээд Ромын соёлд нэвтэрсэн хотын хүмүүсээс цөөн латин үг сурчээ. Латин *castra* эртний англи хэлэнд ромын цайз гэсэн утгатай *ceaster* болж, улмаар Кэлтик элементүүдэд залган Chester, Manchester-хот, Gloucester, Worcester Winchester, Doncaster, Leicester, Exeter, Cirencester, Towcester, Lancaster, Tadcaster зэрэг цөөнгүй газрын болон бусад

нэрийн төгсгөлд үлдэхдээ хойд болон өмнөд нутгийн аялгууны дагуу хэлбэрээрээ бага зэрэг ялгаатай тогтжээ.

МЭ VI зууны сүүлээр Британид Христийн шашныг дэлгэрүүлэхээр Ромоос хэсэг лам ирсэн байна. Тэд үүргээ чадамгай биелүүлж, Англичуудыг Христийн шашинд оруулж дөнгөсөн ба тухайн цагт латин хэлнээс англи хэлэнд орсон үгс голдуу шашин шүтлэг, боловсролтой холбоотой байсан байна. Тэднээс *bishop, candle, creed, font, mass, monk, priest, school, minister, pope, verse* зэрэг үг одоо ч байж л байна. Францын байлдан дагуулалтаас (1066 он) өмнө латин хэлний 400 гаруй үг англи үг болж, зарим нь тэр цагт түгээмэл хэрэглэгдэж байсан бөгөөд тэднээс цөөхөн нь орчин цагийн англи хэлэнд орж ирсэн. Гэхдээ энэ хооронд буюу IX-X зуунд Скандинавиас мөн булаан эзлэгчид ирж Английн зүүн хэсэгт олноор суурьшжээ. Тэднээс өнөө үед ч хэрэглэсээр байгаа өдөр тутмын ярианы олон үг, –by төгсгөлтэй хэд хэдэн газрын нэрийг авчээ. Заримыг дурдвал: *sky, leg, call, take, dirt, Whitby, Derby*.

Эртний англи хэлэнд Энэтхэг Европ овгийн Celtic-ийн салбар хэл болох Briton (Англо-Саксончууд ирж суурьшихаас өмнө Британид амьдарч байсан уугуул оршин суугчдын хэл)-оос авсан үг олон байна гэж үзэх нь олонтаа. Английн хэл бичгийн ухаанаар бичсэн дээр үеийн бичиг, номд энэ эх сурвалжаас гаралтай гэж үзэж болмоор үг нэн элбэг. Гэвч XII зуунаас өмнө англи хэл дээрх кэлтик үг тийм ихгүй ба зарим (*dry*-илбэчин, мөн түүнтэй адил *druid, bratt*-нөмрөггөх мэт) нь Британоос бус, Шотландаас Англи уруу шашин дэлгэрүүлэгчидтэй цуг явсан ирландчуудаас сурсан үг гэж сүүлийн үеийн судалгаагаар баталжээ. *Dun*-гүвээ хэдий кэлтик гаралтай ч, энэ үгийг эх газраас ирсэн Англичууд авчирсан юм. *Binn*-мал ус уудаг урт сав, манайхаар *ховоо, dunn*-өнгөт нэмээд нэг хоёр үгийг үнэхээр Британи арлын хэлээс (*british*) зээлдсэн авч тэдний гарал нь бүхий л талаараа эртний англи хэлний үгийн онцлогийг хадгалжээ. Гэхдээ Британи арлын хүн амыг бүгдийг устгаагүй, эсвэл тэднийг Английн булаан эзлэгчид өмнө зүг рүү хөөсөн гэх баталгаа зарим талаар эргэлзээтэй байгааг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Британийн газар бүрд байгаа одоогийн Англи хүний биемахбодийн хэв шинжүүд тэднийг эртний англичуудын удам гэдгийг баталдаг. Британийн гол мөрөн, хотуудын нэрс өнөө үед олон газар хадгалагдан үлдсэнийг тэмдэглэх хэрэгтэй.

Англи хэлний үгийн санд Скандинавийн орнуудаас, тэр тусмаа Даниас авсан үг үнэхээр

олон. Англи нэгэнтээ Скандинави буюу хойд Европын захиргаанд байхад улс төрийн утгатай дани хэлний олон үг *law, outlaw, grith (legal security-эрх зүйн аюулгүй байдал) hustings, wapentake, riding* ('the three Ridings of Yorkshire' – "Йоркширийн гурван морьтон"-ы гуравдугаар бөлөгт гардаг) орж ирсэн байдаг. Скандинавийн орнуудаас гаралтай бусад үгээс нэрлэвэл: *awe, call, crave, fellow, get, hit, husband, knife, leg, loft, loose, low, odd, root, same, scant, skin, scrap, take, Thursday, thrall, want, wrong. Cross* гэх үгийг латин хэлээс зээлдсэн нь мэдээж, гэхдээ хэлбэрийг нь эртний Скандинавийн иргэн өгсөн. Тэрээр энэ үгийг Ирландын Христ шашинтнаас сурчээ. Эртний англи хэлний одоо ч хэрэглэж байгаа зарим энгийн үг нь Скандинавийн ижил утгатай үгэнд ууссаар байна. Жишээ нь, *sister* эртний англи хэлний *sweostor*-оос бус эртний норс (Old Norse-Скандинавичуудын 1350 оноос өмнө хэрэглэж байсан хойд герман хэл) хэлний *syster*-ээс уламжлагджээ. Дундад зууны англи хэлний *yive* буюу *yeve* (эртний англи хэлэнд *gifan*. Эртний англи хэлнээ 'i'-ийн өмнө орсон 'j' 'y'-(вай)-р дуудагддаг байв. Энэ нь орчин цагийн англи хэлний "y" юм.)-г эртний норс хэлний *gifa* орложээ. Английн хойд болон зүүн зүг, зарим нутгийн төв хэсгийн хэл аялгуунд дани гаралтай үг олон бий.

XI зууны сүүл хүртэлх хугацаанд англи хэл нь гадаад хэлнүүдээс хэрхэн үг авч баяжсаныг авч үзлээ. Харин дараа нь гадаад хэлнээс авсан үгийн тоо нийт үгийн сантай нь харьцуулбал цөөн байв. 1100 онд латин, кэлтик, скандинаваас олон үг авч байсан ба эдгээр бүх үг өнгөрсөн 5 зуун жилийн турш үндсэндээ байж л байв.

1066 онд Франц Британийн арлуудад довтолж булаан эзэлсэн ба энэ нь (Norman Conquest-Францын хойд нутгаас ирсэн) олон шинэ зүйл, нөхцөл байдлыг авчирсан авч нэлээн хожим франц хэлний үг, үг бүтээх дагаврыг англи хэл авч эхэлсэн байдаг. Англи хэлэнд орсон франц үгсийг 1051 оноос хойш тавь тавин жилийн давтамжтайгаар авч үзвэл 1251-1400 оны хооронд хамгийн олон үг орсныг харж болно. Тэр цагт Францаас голдуу удирдах засаглал, эрх зүйн тогтолцоо, мөн хоолтой холбоотой олон нэр томьёо англи хэлнээ орж иржээ. Энэ нь зөвхөн шинэ удирдагчдын хэл төдий байсангүй, судлаачдын олж мэдсэнээр олон англи хүн үүнийг өдөр тутмын амьдралд хэрэглэж байв. Улмаар үүний ярианы үгийн санг эх хэлэндээ авчээ. Тэдгээрээс одоо хүртэл хэрэглэж байгаа заримыг дурдвал: *sovereign, court, govern, parliament, power, minister, chancellor, council,*

feudal. People, nation хоёр эхэндээ улс төрийн нэртомьёо байснаа хожим энгийн үгс болсон юм. Хоолтой холбоотой үгс нь *beef, mutton, veal, pork, bacon, venison*. Эх газрын баялаг уран зохиолыг Франц орон мөн өгчээ. XIII-XV зуунд Английн уран зохиолын томоохон хувь нь франц романсын орчуулгаас бүрдсэн бөгөөд английн шүлэг яруу найрагт франц хэв шинж хүчтэй нөлөөлсөн юм. Эдгээр нөхцөл байдалтай уялдаж, английн уран зохиолын хэл аялгуу франц хэлнээс ихээхэн үгийг авах хэрэгцээтэй тулж, ихэнх франц үг нь аажмаар үгийн санд сайн мэдэх үгс болж орж иржээ. Францын байлдан дагуулалт англи хэлийг цэвэр герман хэлээс холимог үгийн сантай болгов. Францын засаг захиргааны шийдвэрээр утга зохиолын соёл өндөртэй гадаад ламын бүтээлүүдийг английн сүм, хийдүүд хэвлэн гаргаж байсан ба төдий л удалгүй түүх, шашны номлолтой холбоотой бүтээлүүд Францаас орж иржээ. Франц хэлээр бичсэн эдгээр бүтээлд латин үг, нэр томьёог орчуулахгүйгээр буулгасан байдаг. Цаг хугацаа өнгөрсөөр, энэ хугацаанд латин хэлний нэртомьёо бүхий он дарааллын олон бичиг, шашны холбогдолтой ном зохиолыг англи хэлнээ хөрвүүлж амжсан бөгөөд английн дуун хөрвүүлэгчид эх хэлээрээ орчуулахын оронд латин хэлний үгийг шууд зээлж байв. Энэ нь ч тэдэнд хялбар байсан байна. Ерөнхийдөө латин гаралтай олон үг франц хэлээр дамжин Англи хэлэнд орж иржээ.

Англи хэлэнд орсон франц үг хоёр өөр хэл аялгууг илэрхийлж байв. Францын булаан эзлэлтийн шууд үр дүн болж Англид дэлгэрсэн франц хэлний хэлбэр нь Нормэнди (Normandy-урьд нь баруун хойд Францын муж байсан), Рикэрди (Picardy-Францын хойд хэсгийн муж, Нормэндитэй хиллэдэг)-ийн яриа болох хойд зүгийн хэл аялгуу байжээ. Гэвч Ангевиний хааны угсаа (Angevin-Францын баруун хойд хэсгээс ирсэн 1154-1485 онд Англи орныг удирдаж байсан) төр барьж байсан XII зууны дунд үед шинээр орж ирсэн зүйл бол Францын төв хэсгийн хэл аялгуу байв. Энэ нь шүүх засаглал, дээд зиндааныхны хэл аялгуу болжээ. Хоёр хэл аялгуу дуудлагаараа нэлээн ялгардаг. Жишээ нь, хойд францад “к” (“к”) гэж дууддаг гийгүүлэгч төв францад “ch” (ч), харин “ch” нь төв францад “s”-ээр дуудагддаг байв. Эхлээд хойд францын хэлбэрээр англи хэлний үг үүсэж, хожим нь төв францын дуудлагад ууссан цөөн тохиолдол бий. Жишээ нь: одоогийн *charity* нь 1150-иад онд англи хэлэнд *cariteth* хэлбэртэй байсан ба зуун жилийн дараа *charitee* болон гарч иржээ. Франц гаралтай

хуулийн нэртомьёоны дунд *justice, judge, jury, court, cause, assize, fee, crime, damage, penalty, injury, prison* зэрэг үг байна (Bradley, 1964, х.88).

Булаан эзлэгчдийг дагаж хоёр зууны турш Францаас орж ирсэн үгс голдуу ямар төрлийн объект, санааг илэрхийлж байгааг судлах нь сонирхолтой, сургамжтай юм. Хоолтой холбоотой олон нэр томьёо орж ирснийг дээр өгүүлсэн. Тодруулбал *ox* (үхэр), *sheep* (хонь), *calf* (тугал), *swine* (гахай), *deer* (буга) зэрэг амьтны махны нэрийг франц хэлээс зээлжээ. Жишээ нь: *beef* (үхрийн мах), *mutton* (хонины мах), *veal, pork* (гахын мах), *bacon* (утсан гахайн мах), *venison*. Мөн франц гаралтай *servant, butler, buttery, bottle, dinner, supper, banquet* үгс англи хэлэнд байна. Английн хууль, засаглал, эрх мэдэлтэй холбоотой нэртомьёоны дунд франц үг элбэг тааралдана. Жишээ нь: *court assize, judge, jury, justice, prison, gaol, parliament, bill, act, council, tax, custom, royal, prince, county, city, mayor, manor, chattel, money, rent*. Эд бүгд XIII зууны сүүлчээс өмнө орж ирсэн юм. Цэргийн цол, хэргэмийн нэрс эх газраас гаралтай байсан ба онцгой цолуудын ихэнх нь (*duke, marquis, viscount, baron, prince* зэрэг) франц үг байна. Энд нэг тэмдэглүүштэй юм байгаа. Гадаад хэлний *count* (эртний францын *conte*-гүн цол)-ийг англи хэл зээлээгүй. Учир нь англи хэлэнд бараг ижил утгатай өөрийн гэсэн *earl* гэдэг үг байсан байна. Гэвч Англид хатагтай нарт нөхрийнх нь цолтой адилхан нэр өгөх ёсон байдаггүй тул тэдэнд франц хэлний *countess* гэдэг нэрийг өгчээ. Энэ нь гүнгийн зэрэгтэй эмэгтэй, эсвэл гүнгийн эхнэр гэсэн утгатай. Эртний англи хэлний *cniht* (knight) нь франц хэлний адил утгатай *chevalier* гэдэг үгээс богинохон байсан учраас байраа алдсангүй.

Булаан эзлэгчдийн хэлнээс цэрэг, дайнтай холбоотой олон нэртомьёог зээлджээ. *War* бол хойд Францаас орсон үг, үүнтэй адил XIII зууны сүүлчээс өмнө англи үг болсон бусад франц үгийн дунд *peace, battle, siege, mangonel, tower, officer, soldier, troops, dragoon, admiral*, зэрэг үг байна. Эхлээд цэвэр цэргийн нэртомьёо байснаа хожим нь бусад салбарт хэрэглэх болсон зарим үг гэвэл: *challenge, enemy, danger, espy (spy), aid, prison, march, force, company, guard* гэх мэт.

Үйлдвэрлэлийн иргэншлийн үед худалдаачид, гар урчуудтай холбогдох маш олон тодорхойлолт франц гаралтай байв. *The smith*-төмрийн дархан, *the baker*-талх баригч зэрэг цөөн хэдэн үг эртний англи хэлээс уламжлагдсан нэрээ хадгалжээ. Гэвч *the butcher, the barber, the chandler, the carpenter, the cutler, the draper, the mason, the tailor* зэрэг

франц үг олон байна.

Гэр бүлийн харилцаан дахь хамаатнуудын олон нэрлэлийг францаас зээлдсэн нь сонин. *Uncle, aunt, nephew, niece, cousin* зэрэг үг англи хэлнээ орж ирэнгүүтээ нэг их удалгүй үндэсний ижил утгатай үгсийг шахан гаргажээ. XV зуунд хагас-англи *grandfather, grandmother* зэрэг үг хэрэглээнд орж ирсэн байна. *Father-in-law, mother-in-law* зэрэг үг англи бүтээврүүдээс бүрдсэн ч эртний франц хэлний үгчилсэн орчуулгууд юм.

Франц хэлний хольц ороогүй унаган англи үгсийн дунд бие махбодийн гадаад хэсгийг нэрлэсэн үгс орж байна. Энд ч мөн онцолмоор нэг зүйл байгаа нь XIII зууны сүүлээр англи хэлний үгээр анх гарч ирсэн франц хэлний *face* хэмээх үг түгээмэл үгийн санд орсон нь олджээ. Энэ үг эх хэлний ижил утгатай үг болох *onlete, onsene, wlite* нараас хялбар дуудлагатай, богино бичлэгтэй байсан тул англи хэлэнд шууд орж ирсэн хэмээн үзэх бүрэн үндэстэй юм.

Францаас утга зохиолын хэлний үг зээлдэх явдал XII зуунд эхэлсэн ба одоо хүртэл энэ үйл явц үргэлжилсээр л байна. XIII-XIV зуунд амьдарч байсан английн зохиолчид францын утга зохиолын үгсийг уншигчдадаа анх танилцуулжээ. Улмаар тэд хүсвэл франц үгийг нэвтрүүлэх эрхтэйгээ мэдэрчээ. Энэ эрхийг ч тэд чөлөөтэй ашигласан байна: шүлгийн холбоц, хэмнэл гээд утга зохиолд шаардагдах олон чухал зүйлийг тэд эх хэлнээ анх хэрэглэжээ. Ийм маягаар англи хэлэнд тоймгүй олон үг орж ирсэн ба тэдгээр үг хэллэг хэлний түр зуурын хэрэгцээг хангаж, дараа нь хуучирч байсан ч түүнээс олон үг одоо хүртэл оршсоор байна. Энэ үед үргэлжилсэн үгийн зохиолчдын францаас оруулж ирсэн үгс цөөн байсан ба ихэнх нь шинжлэх ухаан, онолын нэр томьёоноос бүрдсэн үгс байв. Англи хэлэнд ийм үг нэн бага байсан юм.

Францын утга зохиолын үгийн санд эртнээс нааш латин хэлнээс орсон үг ихээхэн хувийг эзэлдэг агаад франц дуудлагын дагуу сүүл хэсгээ гээсэн, эсвэл өөр болсон байдаг. Английн зохиолч зохиол, бүтээлдээ латин хэлний үгсийг оруулахдаа франц хэлэнд орсон тэр хэлбэрээр нь бичдэг байсан байна. Тиймээс англи хэлэнд орсон латин гаралтай үгийг латинаас англи хэлнээ шууд орж ирсэн үү, эсвэл францаар дамжсан уу гэдгийг тодорхойлох хэцүү.

Латин үгсийг францаар дамжуулан зээлдэх явц нь яваандаа латинаас шууд зээлдэх үйл явц болов. Латин хэлний элементүүд яагаад бусад герман хэл болох герман, дани, скандинавийн хэлнээс илүүтэй англи хэлний үгийн санд нэлээн түлхүү

орсон шалтгаан нь энэ. Харин герман, голланд хэлэнд латин гаралтай судалгааны үг английнхаас олон байх магадтай.

Орчин цагийн англи хэлэнд унаган англи болон франц гаралтай үгийн тоотой харьцуулахад латин хэлний элемент их байдаг. Ер нь латин үгийг англичлах, эсвэл уг хэлний элементээр шинэ нийлмэл үг бүтээх нь жинхэнэ англи нийлмэл болон үүсмэл үг бүтээхээс хялбар байдаг нь нууц биш.

Баруун Европ дахь Герег судлалын сэргэн мандалт, түүний нөлөө XVI зууны эхнээс энэ оронд мэдэгдэж эхэлсэн ба англи хэлний үгийн санг баяжуулах шинэ эх сурвалжийг нээж өгчээ. Үүнээс өмнө ч англи хэлэнд *geography, theology, logic* зэрэг тодорхой тооны грек үг байх нь байсан. Тэдний ихэнхийг францаар дамжуулан авдаг байсан ба эдгээр бараг бүх латинжсан герег үгевропын бүх утга зохиолын хэлэнд орж иржээ (Bradley, 1964, х.97). XVI-XVII зуунд ихээхэн хувийг эзэлж байсан латин хэлний үгс шинжлэх ухаан, философи, утга зохиолынх байсан ба герег гаралтай техникийн шинэ нэр томьёонууд төрөлх хэлнээсээ түрүүн латин хэлэнд өргөн хэрэглэгдэж байв. Герег хэлнээс зээлдсэн шинэ үг англи болон орчин цагийн бусад хэлэнд орж ирэхдээ латин хэлээр дамжсан байдалтай байдаг. Герег хэлний тэмдэг нэрсийг англичлахдаа латин хэлний тэмдэг нэрстэй адил *-ous, -an, -al* дагавар залгаж англи үг болгосон ба ийм маягаар *autonomos, diaphanes* буюу одоогийн *autonomous, diaphanous* үүсчээ.

Герег судлал хэдийгээр нэгэн зуун үргэлжилсэн ч англичуудын дээд боловсролын чухал хэсэг болж ирсэн ба шинжлэх ухаанд техникийн нэр томьёогоороо англи хэлний үгийн санд багагүй хувь нэмэр оруулсан байна. Герег хэлний техникийн үгийн сан тусгалаа олсон, ойлгомжтой, нарийвчлал сайтайгаараа гайхамшигтай.

Өнгөрсөн хоёр зуун гаруй жилийн турш физикийн шинжлэх ухааны өндөр хөгжил олон тооны шинэ шинэ нэр томьёо бүтээх хэрэгцээ үүсгэжээ. Улмаар одоогийн том толь бичгүүдээс үгийн гарлыг нягталбаас гайхалтай зүйлийг харах бөгөөд энэ нь байнга өсөн нэмэгдэж байгаа тоймгүй олон герег үг юм. Мөн үүн дээр нэмээд XX зууны эхэнд нээсэн орчин үеийн тоног төхөөрөмж, ажиллагааны маш олон нэрийг герег гаралтай шинжлэх ухааны нэр томьёо эзэлж байна. Заримыг дурдвал: *photography, lithography, srereotype, telephone, cinematograph*. Энэ эх сурвалжаас авсан орчин үеийн шинжлэх ухаан, техникийн үгийн ихэнх нь олон улсын нэртомьёо болж хэвшсэнийг тэмдэглэмээр байна. Европ,

Америкийн бүх соёлт оронд герег элементээр нийлмэл үг бүтээх хэв шинж тархсан байдаг ба тэрхүү чухал нэр томьёо нь Англи, Франц, Герман, Голланд, Итали, Испани зэрэг орны аль нэгэнд бий болж улмаар дэлхийн бусад үндэстэнд тархдаг байна (Henry Bradley, 1964, х.100).

Англи хэлэнд шууд болон дам орж ирсэн герег хэлний бараг бүх үг шинжлэх ухаан, техникийн гаралтай байсан. *Fancy, idea, ecstasy, sympathy* мэт олон үг эрт цагт орж ирсэн ч одоогийн түгээмэл үгийн санд хэдийн байраа эзэлжээ. Гадаад хэлнээс орж ирсэн эдгээр үгийг судалгааны хэл ч гэдэг. Герег, латин үгсээс дурдвал, *alphabet, area, apparatus, atmosphere, chemist, circus, crisis, disaster, energy, function, genius, idea, idiom, machine, method, system, theory, thermometer, vacuum* (Sheard, 1962, х.253).

1500 оноос хойш өнгөрсөн 5 зууны турш Англи болон Европын алс холын үндэстнүүдийн хоорондох харилцаа өргөсч, ойртож эхэлсэн ба тэдгээр орны уран зохиолыг Англи судалсаар иржээ. Тэр цагт Англи оронд нээлт, колончлолын асар хүчтэй дэвшил явагдаж, энэ нь нутгийн англи иргэдийн хэл, ёс заншилд төдийгүй дэлхийн алс хязгаар орнуудад илэрч эхэлсэн юм. Улмаар, ялангуяа Сэргэн мандалтын үеэс орчин цагийн англи хэлний үгийн санд Европын бүх соёлжсон хэл, Ази, Африк, Америк, Австралийн олон арван хэлний үг багтах болжээ.

XVI зуунаас хойш итали хэлнээс олон нэр томьёо зээлсэнээс хөгжим, уран барилга, дүрслэх урлагийнх илүүтэй байна. Заримыг дурдвал: *balcony, corridor, sonata, aria, basso, fantasia, opera, piano, concerto, mandolin, macaroni* болон *busta, dado, fresco, ovolo, studio, pizza, umbrella*. Эднээс зарим нь Францаар дамжин орж иржээ. Италид XIV зуунд сонгодог урлаг, уран зохиол анх үүсч, XVII зуун хүртэл хөгжихдөө Европын орнуудад дэлгэрчээ. Энэ үед Англид утга зохиол, утга зохиол шүүмжлэлтэй холбоотой маш чухал олон нэр томьёо орж ирсэн байдаг. XVI зуунд Италийн уран зохиолуудыг англи хэлнээ орчуулах ажил хүчтэй өрнөж байсан ба Уайэт, Сэрий, Спэнсэр, Милтэн зэрэг зохиолч итали загварыг ихээр хэрэглэж байв. Мөн тэдний амьдрал, зан заншил, хувцас хунар, нийгмийн шинжтэй *attitude, cicerone, fiasco, isolate, motto, umbrella, gazette, casino, conversazione, traffic, risk, Lombard* зэрэг үг англи хэлнээ орж ирэв. (Өнгөрсөн зууны 90 хэдэн оноос монгол хэлний үгийн санд “барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ” гэж оноосон “ломбард” хэмээх үг тэгэхээр итали гаралтай байх нь. Орч.) Цэргийн нэр томьёоноос *armada, embargo*

гэх мэт үг испани хэлээс орж ирсэн (Jespersen, 1962, х.142). Зураачийн хэрэгсэл заах үг голдуу Нидерландийнх байна. Жишээ нь: *landscape, sketch, easel, maulstick*. Даниас *aloof, avast, boom, dock, hull, skipper, orlop, flyboat, euphroe, rover* зэрэг далай тэнгисийн олон нэр томьёо авчээ. Испаниас *sherry, ambuscade, desperado, grandee, negro, peccadillo, renegade*, Пэрсээс *caravan, dervish, paradise* (францаар дамжин), Унгараас *hussar, shako*, Түркээс *bey, caftan*, Арабаас математик, одон орон, шинжлэх ухааны холбоотой *algebra, zero, alchemy*, худалдаатай холбоотой *kofe, cotton, alcohol sofa, harem, mufti*, Малайгаас *bamboo*, Полинезээс *taboo*, Австралаас *boomerang, wombat*, Мексикээс *chocolate, tomato*, Америкийн бусад хэлээс *moccasin, totem* гэх мэт. Төв болон өмнөд хэсгийн уугуул герман (High German) хэлээс орсон цөөхөн үг бий: *bismuth, blende, cobalt, gneiss, quartz, shale, zinc*. Эд бол шинжлэх ухааны эгнээнд анх орж ирсэн эрдэс судлал, уул уурхайн нэр томьёо юм Кант, түүнийг баримтлагч хэсэг англичууд германаас философийн нэр томьёо оруулж иржээ. Энэтхэгээс *pundit, baboo, thug, durbar* гэх мэтийн үг орж иржээ.

XVII зуунд шинжлэх ухаан маш хурдацтай хөгжиж, олон шинэ шинэ ухагдахууныг тэмдэглэхэд латин хэлний үгийг ашиглаж байсан ба Ньютон, Бойл нар бүтээлээ латинаар бичиж байв. Мөн энэ зууны сүүлээр хүний биеийн эрхтэн, ясыг латин, герег хэлний үгээр тэмдэглэж байжээ. Шинжлэх ухааны зарим салбар, тухайлбал анагаах ухаан, ботаник, байгалийн түүх, биологийн хөгжил бусдаасаа түрүүлж байв. Харин хими, алхимийн хөгжил удаан байсан тул шинэ нэр томьёо ч цөөхөн байв (Sheard, 1962, х.263).

Европын бусад хэл, мөн дэлхийн алс хязгаарын хэлүүдээс авсан англи үгийн ихэнх нь гадаадынхны ёс заншилтай холбоотой нэр томьёо, эсвэл гадаадын бараа, бүтээгдэхүүний нэр байна. Португалаас *auto-da-fe, albatross, cocoa, dodo, verandah*; орчин цагийн герег хэлнээс *valonia*; орос хэлнээс *drosky, knout, verst, steppe*; турк хэлнээс *caftan, coffee, effendi, horde*; Африкаас *banana, hip, jazz, okay, samba, seagull, tango, yam*, Энэтхэг (мөн Санскрит)-ээс *jungle, curry, shampoo, brother, Buddha, orange*, орчин цагийн скандинавийн хэлүүдээс *sky, eider, geysir, kraken, sloyd, tungsten*, Чехээс *dollar, robot* гэх мэтээр. Англи хэлэнд малай хэлний үг их байдаг. Тэдгээрээс ихэнхийг нь цөөн хүн мэддэг авч *gingham, gong, gutta-percha, lorry, orang outan, amuck, ketchup* зэрэг Англичуудын сайн мэдэх үгс бий. Хятад хэлнээс *chopstick, kowtow, ketchup, kung fu, maotai, typhoon,*

tofu, yamen, oolong, tea-цай, цайны олон төрлийн нэр, түүнчлэн Long time no see (好久不见 Удаан уулзсангүй) гэх мэт хэллэг авчээ. Эдгээрийг жинхэнэ англи үг болсон гэж хэлэхээргүй ч, томоохон толь бичгүүдэд орсон байгаа. Японоос тухайн орны аж төрөх ёс, урлагтай холбоотой нэртөмьёо *haiku, karaoke, tycoon, kimono, ramen, judo, karate, sumo, sudoku, tsunami, солонгосоос taekwondo, kimchi, kimbar, soju*, полизенийн хэл аялгуунаас өдөр тутмын *taboo, tattoo* гэдэг хоёр үгийг авчээ. Шинэ ертөнцийн хэлүүд (Languages of the New World) хэдэн зуун үгийг бүрдүүлж өгсөн байна. Хэдий тэднээс олон үг, жишээ нь, *squaw, wigwam* нарыг зөвхөн харьяалах салбарынхан мэддэг хэдий ч гадаад үг гэж ер бодохооргүй *tobacco, potato, toboggan, moccasin, pemmican* зэрэг цөөнгүй үг бий. Спорт, банкны чек зэрэг үг англи хэлэнд XX зууны эхний хагаст орж ирсэн юм (Jespersen, 1962, х.130).

Гадаад хэлнээс үг зээлснээр англи хэлний үгийн сан нэн баялаг болж, улмаар орчин цагийн толь бичигт орсон бүх үгийн маш цөөхөн хувийг үндэсний гаралтай үг эзлэх болжээ. Толь бичигт орсон үгсийн дөрөвний гурвыг өндөр боловсролтой хэсэгхэн хүмүүс мэддэг. Гэхдээ л орчин цагийн тууж, өгүүллийн үгийн санг ажиглавал эртний англи хэлнээс гаралтай үгс бусад хэлний үгээс тоогоор хавьгүй илүү байгааг харж болно. Өөрөөр хэлбэл, шинэ залуу зохиолчид зохиол бүтээлдээ эх хэлний үгсийг голдуу хэрэглэдэг байна.

Англи хэлнээ орж буй гадаад хэлний үгс нь англи хэлийг бэхжүүлэхийн оронд доройтуулж байна, франц, латин хэлнээс үг авахын оронд герман хэл шиг эх хэлний нөөцөөрөө нийлмэл үг бүтээх, эсвэл шинээр үг бүтээх нь илүү дээр байсан юм гэсэн маргаан судлаачдын дунд байнга гардаг. Ингэж үздэг хүмүүсийн зарим нотолгоо үнэний хувьтай. *Mind ba mental; eye-ocular; sun-solar; moon-lunar; bone-ossify* зэрэг англи хэлэнд орсон зарим үгэнд утгандаа тохирсон харилцаа үүсдэггүй нь этгээд үзэгдэл. Харин *paternal-fatherly, fraternity-brotherhood, celestial-heavenly, fortune-luck, felicity-happiness, royal-kingly* зэрэг ижил утгатай авч утгыг нь нарийн авч үзвэл бас ялгарах эдгээр үг нь хэлээ мэдэх англи хүнд бол маш бодитой, ойлгомжтой, харин бусад хэл рүү орчуулахад хялбаргүй.

Ерөнхийдөө нэг зүйлийг ойролцоогоор илэрхийлж байдаг хоёр үгийг авч үзэхэд, нэг нь үндэсний, нөгөө нь латин, эсвэл франц гаралтай үг байвал сэтгэлд арай ойр, утгаа илүү сайн илэрхийлж байдаг нь эх хэлний үг байдаг нь үнэн.

Үүнийг батлахаар зарим зохиолч латин гаралтай үгсийг англо-саксон хэлний үгээр солихыг хичээх буюу тавьдаг. Тэгээд ч ингэх боломжтой. Хамгийн сайн тохирсон авч үндэсний гаралтай биш л бол ёсорхуу англичууд тэр үгээс татгалзахыг оролддог. Тэд герег, латин хэлнээс орж ирсэн шинжлэх ухааны нэртөмьёог басамжлангуй хүлээн авдаг онцлогтой. Гэвч шинжлэх ухааны салбар бүрд өөрийн гэсэн нэг л тодорхой утгыг илэрхийлэх нэр томьёотой үгийн сан зайлшгүй хэрэгтэй нь үнэн.

Хэлийг бохирдуулж гадаад үг оруулахыг нүгэл мэтээр үздэг эмзэг пуристуудын маргаан заримдаа дэмий мэт. Утгаа бүрэн илэрхийлж чадаж байгаа үгсээр нь хэлний үнэ цэнийг үнэлвэл англи хэл нь харь хэлний элементийг нэгтгэснээр өөрийгөө хэмжээлшгүй их сайжруулж ирснийг үгүйсгэх аргагүй. Эртний англи хэлний цөөхөн үгийн сан харь хэлний тусламжгүйгээр нөөцөө ашиглан цэврээр хөгжин элбэг үгтэй болсон ч, өнөө үед ингэх боломжгүй нь тодорхой. Одоо ч гэсэн голдуу шинжлэх ухааны салбарт латин, герег үгс шинэ үгийн эх сурвалж болсоор байна. Харин бусад хүрээнд онцгой зүйл, гоц үзэгдэл, ямар нэгэн шинээр нээгдсэн обьёоктод нэр өгөхдөө англи хэлэнд нэрлэх нэр, нэртөмьёо байхгүй бол дэлхийн бусад хэлнээс л зээлж байна. Сүүлийн үед англи үг болж хараахан амжаагүй байгаа үг, хэллэг голдуу латин, франц, герег, итали хэлээс орж иржээ.

Орчуулагчийн дүгнэлт. Ямар гадаад үг, хэзээ, хэрхэн тухайн хэлэнд орж ирсэн бэ гэдэг асуудлыг мөшгих юм бол тухайн үеийн нөхцөл байдал тодордог. Өөрөөр хэлбэл, харь хэлний үгс орох явц нь нийгэмтэйгээ холбогдож, цаг үеийнхээ тусгал болдог байна. Үүнд худалдаа арилжаа, шашин шүтлэг, соёлын солилцоо зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг. Эрт цагт их гүрнүүдийн жанжлах бодлого, эзлэн түрэмгийлэлт, хүн амзүйн түрэлт ч нөлөөлж ирсэн. Манай улсын хувьд жишээлэхэд, хятадтай харилцаа зузаарсан он жилүүдэд, ялангуяа Юань гүрний үед хятад гаралтай олон үг, голчлон урлаг, худалдаа, хоолтой холбоотой үгс болов уу, монгол хэлний үгийн санд орж ирсэн бол, Манжийн дарангуйллын үед манж үг, Буддын шашны дэлгэрэлтийн үед төвд, санскрит гаралтай үг, XX зууны Зөвлөлтийн нөлөөний он жилүүдэд орос үг, 25 жилийн өмнөх нийгмийн шинэчлэлийн давалгаанаар Англи, Солонгос, Япон зэрэг олон хэлний үг түлхүү орж ирж байна. Монгол гаралтай үгс ч дээрх орнуудад төдийгүй, дэлхийн олон хэлэнд орсон. Хүйтэн дайн төгсгөл болж, улс түмнүүд хоёр туйлд хуваагдахаа зогсоож, үзэл

суртлын сөргөлдөөн арилж, улам бүр даяаршиж байгаа энэ цаг үед аливаа улс орон бүрийн үгийн санд харь хэлний үг олноор орж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор хэлний бодлого, хэлний асуудал хүчтэй тавигдах болов. Шинжлэх ухааны шинэ нээлтүүд, шинэ тутам үүсэж байгаа ахуй амьдралын олон зүйл, хилийн чанадаас орж ирж буй зөвхөн тухайн ард түмэнд л байдаг-үндэстний онцлогийг тээсэн сонин содон зүйлс, эд бүгдийг тухайн хэлрүү орчуулсан ч бай, утга ижил үгээр орлуулсан ч бай, шинэ үг үүсгэсэн ч бай, гадаад нэрээр нь шууд хуулбарласан ч бай, ямартай ч энэ бүхэн эх хэлний үгийн санг баяжуулж, өөриймшүүлж авдаг зайлшгүй үйл явц билээ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Henry Bradley.(1964).*The making of English*.New York

J.A Sheard. (1962). *The words we use*. London

Otto Jespersen (1962).*Growth and structure of the English language*.Great Britain.

<http://en.wikipedia.org>

<https://www.englishclub.com/english-language-history.htm>

Орчуулсан Ц.Өлзий
ШУА, Түүх-Археологийн хүрээлэн